



## ТАНИЛЦУУЛГА

*Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тухай*

“Монгол Улсын 2025 оны төвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 54 дүгээр тогтоолын 1.1 дэх хэсэгт “чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шийдвэрлэх”-ийг Засгийн газарт даалгасан.

Иймээс, бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн, төсвийн зарлагын санхүүжилтэд эрэмбэ тогтоож, төсвийн захирагч нарын төсвийн сар, улирлын санхүүжилтийн хуваарьт зохицуулалт хийх, зарцуулагдаагүй үлдэгдлийн санхүүжилтийг хойшлуулах арга хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагад өөрчлөлт оруулах шаардлага үүсэж байна.

### **Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн зүйл тус бүрээр:**

***1 ДҮГЭЭР ЗҮЙЛ –Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:***

***“3 дугаар зүйл. Дээр дурдсан төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх шинэчилсэн орлогын хэмжээг хүснэгтээр тусгасан.***

***5 дугаар зүйл. Дээр дурдсан төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын санд 2025 оны төсвийн жилд зарцуулах төсвийн шинэчилсэн хэмжээг хүснэгтээр тусгасан.***

**2 ДУГААР ЗҮЙЛ** – Энэ хуулийг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.  
Хуулийг мөрдөж эхлэх огноог тусгасан.

---oO---